



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2024 оны 07 сарын 24 өдөр

Дугаар А/1335

Улаанбаатар хот

Магадлан итгэмжлэл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/503 дугаар тушаалын 3.1 дэх хэсэг, Магадлан итгэмжлэх зөвлөлийн 2024 оны 9 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын нэрсийг хавсралтаар баталж, батламжийг олгосугай.

2. Магадлан итгэмжлэлийн хугацаанд тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулж, шинжээчдийн багийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2024 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн есдүгээр хурлын шийдвэрийг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (С.Эрдэнэтуяа)-т, Эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа)-д тус тус даалгасугай.

4. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн наймдугаар хурлын шийдвэрээр Онцгой байдлын ерөнхий газрын харьяа давтан сургалт сэргээн заслын төв 113 дугаар анги Жаргалант сувиллын оноосон нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан өмнө олгогдсон батламжийн нэрийг "Жаргалант" сэргээн засах төв 113 дугаар анги гэж өөрчлөн, батламжийн дугаар, хугацааг хэвээр олгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналтын газар (Л.Гэрэлмаа)-т даалгасугай.

САЙД



Т.МӨНХСАЙХАН

141241419

Эрүүл мэндийн сайдын 2024 оны
07 дугаар сарын 24 өдрийн
8/335 дугаар тушаалын хавсралт

МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН
ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭРС

№	Эрүүл мэндийн байгууллагын нэрс	Батламжийн дугаар	Магадлан итгэмжлэгдсэн хугацаа	Магадлан итгэмжлэл эхлэх огноо	Магадлан итгэмжлэл дуусах огноо
1.	Нийслэлийн Чингэлтэй дүүрэг, Мөнх үйлстэн өрхийн эрүүл мэндийн төв	199/2024	1 жил	2024.07.27	2025.07.27
2.	Нийслэлийн Баянгол дүүрэг, Арвин хурд өрхийн эрүүл мэндийн төв	200/2024	1 жил	2024.07.22	2025.07.22
3.	Нийслэлийн Баянгол дүүрэг, Хаппи доктор өрхийн эрүүл мэндийн төв	201/2024	1 жил	2024.07.22	2025.07.22
4.	Нийслэлийн Баянгол дүүрэг, Чин гэгээн өргөө өрхийн эрүүл мэндийн төв	202/2024	1 жил	2024.07.22	2025.07.22
5.	Нийслэлийн Баянзүрх дүүрэг, Ерөөл буян оршихуй өрхийн эрүүл мэндийн төв	203/2024	1 жил	2024.07.22	2025.07.22
6.	Нийслэлийн Баянзүрх дүүрэг, Хонхор тосгоны эрүүл мэндийн төв	204/2024	1 жил	2024.07.25	2025.07.25
7.	Улаанбаатар хот, Натул ХХК-ний нэгдсэн эмнэлэг	205/2024	2 жил	2024.08.13	2026.08.13
8.	Улаанбаатар хот, Филошийп ХХК-ний эмнэлэг	206/2024	2 жил	2024.08.05	2026.08.05
9.	Улаанбаатар хот, Лона ХХК-ний сувиллын газар	207/2024	1 жил	2024.08.05	2025.08.05
10.	Улаанбаатар хот, Хүүхдийн сэргээн засах Хан туул төв	208/2024	2 жил	2024.07.21	2026.07.21
11.	Улаанбаатар хот, Монгол фарм дистрибьюшн ХХК-ний эмнэлэг	209/2024	2 жил	2024.07.25	2026.07.25
12.	Баянхонгор аймаг, Богд сумын эрүүл мэндийн төв	210/2024	2 жил	2024.08.01	2026.08.01

№	Эрүүл мэндийн байгууллагын нэрс	Батламжийн дугаар	Магадлан итгэмжлэгдсэн хугацаа	Магадлан итгэмжлэл эхлэх огноо	Магадлан итгэмжлэл дуусах огноо
13.	Баянхонгор аймаг, Гурванбулаг сумын эрүүл мэндийн төв	211/2024	2 жил	2024.08.01	2026.08.01
14.	Баянхонгор аймаг, Аймгийн нэгдсэн эмнэлэг	212/2024	1 жил	2024.07.22	2025.07.22
15.	Булган аймаг, Рашаант сумын эрүүл мэндийн төв	213/2024	2 жил	2024.07.25	2026.07.25
16.	Өвөрхангай аймаг, "Оточжаргалан" ХХК-ний "Ариунсанаа" эмнэлэг	214/2024	2 жил	2024.08.03	2026.08.03
17.	Өвөрхангай аймаг, Сидар медикал ХХК-ний "Сидар Мед" эмнэлэг	215/2024	1 жил	2024.07.22	2025.07.22